

БАТЛАВ
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
ЗАЛУУЧУУДЫН САЙД

Чура Ч.УНДРАМ

2025 оны 07 сарын 30 өдөр

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ БҮТЭЭЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 401 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал олгох журам”-ыг удирдлага болгон монголын утга зохиолын хөгжил, шинэчлэл болон ард түмнээ соён гийгүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан бүтээл туурвисан зохиолч, яруу найрагч, судлаач, орчуулагч, шүүмжлэгч болон монголын түүх, хэл, соёл, ёс заншил, нүүдлийн соёл иргэншил, шашин, гүн ухааны судалгааг хийж нийтийн хүртээл болгосон гадаадын иргэнд Д.Нацагдоржийн нэрэмжит шагналыг олгоно.

Хоёр.Бүтээлд тавигдах шаардлага

2.1.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний язгуур эрх ашигт харшлахгүй байх;

2.1.Хүчирхийлэл, садар самууныг илэрхийлсэн утга агуулгагүй байх;

2.2.Зохиогчийн эрхийн болон түүнд хамаарах аливаа эрхийн зөрчилгүй байх;

2.3.Шагналд нэр дэвшиж буй бүтээлээр өмнө нь шагнал хүртээгүй байх;

2.4.Бүтээлийг эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, мэргэжлийн холбоодын удирдах болон эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байх;

Гурав.Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

3.1.Удирдамжийн 2 дугаарт заасан шаардлага хангасан бүтээл туурвисан Монгол Улсын зохиолч, яруу найрагч, судлаач, орчуулагч, шүүмжлэгч болон монгол судлалын чиглэлээр бүтээл туурвисан гадаадын иргэний нэрийг дараах материалын хамт 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор комисст ирүүлнэ.

3.1.1.нэр дэвшигчийн болон бүтээлийн товч танилцуулга;

3.1.2 нэр дэвшиж буй бүтээлийн хэвлэмэл болон цахим хувилбар;

3.1.3.нэр дэвшүүлсэн байгууллагын удирдах болон эрдмийн зөвлөлийн шийдвэр, хуралдааны тэмдэглэл;

3.2.Монгол судлаач гадаадын иргэний нэр дэвшүүлсэн бүтээлд гадаад, дотоодод үнэлэгдэж судлагдсан байдлыг хавсаргана.

3.3.Нэр дэвшигч нь тогтоосон хугацаанд материал ирүүлээгүй, удирдамжийн 3.1-т заасан бүрдэл дутуу материал ирүүлсэн тохиолдолд комисс хүлээн авахгүй.

Гурав. Комиссын бүтэц, эрх үүрэг

3.1. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/248 дугаар тушаалаар байгуулагдсан зохиолч, судлаач, шүүмжлэгч, эрдэмтэд, төрийн захиргааны байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус комисс нь шалгаруулалтыг зохион байгуулна.

3.1.2. комиссын гишүүд хуралдаанд оролцох үүрэгтэй бөгөөд нийт гишүүдийн дөрөвний гурваас доошгүй хувь нь хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдаан хүчинтэйд тооцно.

3.1.3. комиссын гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаанд ирэх боломжгүй тохиолдолд хуралдаанаас өмнө мэдэгдэх үүрэгтэй.

3.1.4. комиссын гишүүн нь өөрөө нэр дэвшсэн тохиолдолд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гишүүнээс татгалзах үүрэгтэй.

3.1.5. хуралдаанд оролцсон гишүүдийн саналыг илээр хурааж, оролцсон бүх гишүүд гарын үсэг зурснаар комиссын дүгнэлт баталгаажна.

3.1.6. комисс нь нарийн бичгийн даргатай байх бөгөөд хуралдааны тэмдэглэл, бүтээлд өгсөн үнэлгээ, дүгнэлтийг холбогдох баримт бичгийн хамт зохих журмын дагуу архивд шилжүүлнэ.

Тав. Шагналд нэр дэвшсэн бүтээлийг хэлэлцэх, шагнал олгох

5.1. Комисс нь шалгаруулалтыг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хэлэлцэж, дүгнэлт гарган, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

5.2. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал олгох шийдвэрийг тушаалаар баталгаажуулна.

5.3. Шалгарсан Монгол Улсын болон гадаадын 3 хүртэлх иргэнд Их зохиолчийн мэндэлсэн өдрөөр шагналыг гардуулна.

5.4. Шагналыг их зохиолч Д.Нацагдоржийн дүр бүхий тэмдэг, гэрчилгээ, мөнгөн шагнал 3.000.000 (гурван сая) төгрөг дагалдана.

5.5. Шагнал хүртсэн бүтээл нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгэгдэх бөгөөд Монгол Улсын Үндэсний номын сангийн сан хөмрөгт хадгалагдана.

--000--